

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

“Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах” тухай Монгол Улсын Засгийн Газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр батлах

ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлалаа.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд иргэнд шууд үүрэг бий болгосон заалт агуулаагүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

ГУРАВ. ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Төслийн нийт төсөвт өртөг ОХУ-ын Интер РАО Экспорт компанийн 2022 онд боловсруулсан техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ээр нийт 1,326.9 сая евро (НӨАТ-тай дүн 1,486.9 сая евро) бөгөөд санхүүжилтийн 15 хувийг буюу 199 сая еврог Монголын талаас, 85 хувийг буюу 1 тэрбум 127.9 сая еврог ОХУ-ын экспортын зээлээр санхүүжүүлэхээр тусгасан.

Эрчим хүчний яам болон “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-аас уг төслийн ТЭЗҮ-г судалж, эрчим хүчний салбарт хэрэгжиж буй бусад дулааны цахилгаан станцын төслүүдийн жишиг үнийн тооцооллыг ашиглан Монголын тал өөрийн хөрөнгөөр тус төслийг санхүүжүүлж хэрэгжүүлсэн тохиолдолд 814.3 сая ам.доллараар (НӨАТ-тай дүн 915.1 сая ам.доллар) хэрэгжүүлэх, төслийн барилга угсралтын ажлын хугацааг нэгээс хоёр жилээр бууруулах боломжтой гэж үзсэн бөгөөд ОХУ-ын Интер РАО Экспорт компанитай удаа дараа уулзалт хийж, төслийн нийт төсөвт өртгийг бууруулах саналыг танилцуулсан.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн 2023 оны 12 дугаар сард Москва хотод ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн сайд бөгөөд Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга А.А.Козловтой уулзалт хийх үеэр “Дулааны гуравдугаар цахилгаан станц”-ыг нийт 300 МВт (50+250 МВт)-аар үе шаттай өргөтгөн, шинэчлэх төслийн талаар санал солилцон, төслийн хэрэгжилтийг хангах замын зураглалыг шинэчлэн байгуулсан.

Төслийн шинэчилсэн замын зураглалын дагуу тус төслийн нийт төсөвт өртөг болон барилга угсралтын ажлын хугацааг нарийвчлан тодорхойлохын тулд эхний ээлжинд төслийн зураг төсөл боловсруулах ажлыг Монголын тал өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх, тухайн зураг төслийн санхүүжилтийг хоёрдугаар ээлжинд барилга угсралтын ажлын нийт төсөвт Монголын талын гаргасан санхүүжилтэд оруулан тооцохоор харилцан тохиролцсон. Энэ хүрээнд Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2024 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр байгуулсан.

Тус хэлэлцээрийн Дөрөвдүгээр зүйлд зураг төслийн гэрээг Монголын талаас эрх олгогдсон байгууллагын өөрийн хөрөнгөөр, эсхүл Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ гэж заасан. Хэрэв Монголын талаас эрх олгогдсон байгууллага буюу “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК санхүүжүүлэх тохиолдолд “Хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн дагуу хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцлоо.

ОХУ-ын Интер РАО Экспорт компани 2022 оны ЭКС/ОКЛК/3 дугаартай албан бичгээр төслийн зургийн ажлыг 19.80 сая евро (НӨАТ-гүй)-гоор гүйцэтгэх үнийн саналыг ирүүлсэн. Тус саналын дагуу зургийн ажлын өртөг 21.78 сая евро (НӨАТ-тай) болох бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн Монгол банкны албан ханшаар урьдчилсан байдлаар тооцож үзэхэд 81.25 тэрбум төгрөг болно.

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн сүүлийн 3 жилийн орлогын тайланг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Орлогын тайлан 2021-2023 он, төгрөгөөр

Үзүүлэлт	2021	2022	2023
Борлуулалтын орлого	128,421,637,338.54	131,465,185,913.68	162,548,726,483.20
Борлуулалтын өртөг	118,184,413,802.04	125,961,233,517.27	148,991,693,705.58
Нийт ашиг	10,237,223,536.50	5,503,952,396.41	13,557,032,777.62
Бусад орлого	563,130,843.65	726,943,264.98	935,168,689.07
Бусад үйл ажиллагааны зардал	10,775,903,783.96	12,711,807,967.84	15,600,577,090.92
Татвар төлөхийн өмнөх ашиг	24,550,596.19	(6,480,912,306.45)	(1,108,375,624.23)
Орлогын татварын зардал	588,443.53	-	22,196,903.10
Татварын дараах ашиг	23,962,152.66	(6,480,912,306.45)	(1,130,572,527.33)

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн сүүлийн 3 жилийн мөнгөн гүйлгээний тайланг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Мөнгөн гүйлгээний тайлан 2021-2023 он, төгрөгөөр

Үзүүлэлт	2021	2022	2023
Үйл ажиллагааны мөнгөн орлого	125,404,661,630.65	141,072,578,908.34	173,234,087,469.29
Үйл ажиллагааны мөнгөн зарлага	111,885,707,308.23	127,538,069,758.33	162,683,656,104.15
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	13,518,954,322.42	13,534,509,150.01	10,550,431,365.14
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлого	5,884,435.40	-	221,966,724.48
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлага	7,541,069,861.43	12,416,818,707.01	11,743,382,914.79
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-7,535,185,426.03	-12,416,818,707.01	-11,521,416,190.31
Санхүүгийн мөнгөн орлого	-	-	-
Санхүүгийн мөнгөн зарлага	4,265,760,387.46	225,415,199.33	213,415,199.32

Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	-4,265,760,387.46	-225,415,199.33	-213,415,199.32
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,718,008,508.93	892,275,243.67	-1,184,400,024.49

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн 2021-2023 оны орлогын болон мөнгөн гүйлгээний тайлангаас харахад “Хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн дагуу үүсэх нэмэлт зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх санхүүгийн боломж бүрдээгүй байна.

Иймд Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн дагуу үүсэх нэмэлт зардлын хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд тус станцын сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний тарифыг 2025, 2026 онд тарифын зохицуулалтаар шийдвэрлэхээр төлөвлөж байна.

ДӨРӨВ. ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ТӨРД

ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Монгол Улсын Улаанбаатар хотын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн зураг төсөл боловсруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлд зураг төслийн гэрээг Монголын талаас эрх олгогдсон байгууллагын өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа тул “Хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт зардал үүсгэхгүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ